БАТЛАВ

"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ"
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Д.ОЮУНБОЛД

"АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН МАГАДЛАШГҮЙ АЖЛЫН ЗАРДЛЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ" БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 10 сарын 03 -ны өдөр № 09/2025 Улаанбаатар хот

1. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага:
   - "Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр 2025-2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө".
   - Авто замын тухай хуулийн 4.1.21, 20.8, 20.9 заалтууд
   - Авто замын тухай хуулийн 20.10.-т магадлашгүй ажлын зардлыг тооцох аргачлал нь санхүү, төсвийн болон авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална гэсэн зүйл заалт хэрэгжээгүй байна. Иймд магадлашгүй ажлын зардлыг тооцох аргачлал боловсруулж гаргах, батлагдсан журам, маягтын дагуу магадлашгүй ажлын зардлыг тооцох, нөөц хөрөнгийг үр дүнтэй зарцуулах хэрэгцээ шаардлага үүссэн.
   - Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 256 дугаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" ЗЗБНбД 81-013-2019-н 5.4.1-т: "Зам барилгын ажлын явцад захиалагч, гүйцэтгэгч байгууллагын аль аль нь урьдчилан харах боломжгүй байсан нөхцөл байдлаас үүсэн гарч болох нэмэлт ажлыг "Магадлашгүй ажил" гэх бөгөөд уг ажлын төлбөрийг шууд зардлын дүнгээс 2 хувиар тооцно. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын явцад зайлшгүй хийх нэмэлт ажлыг магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлнэ."
2. Зөвлөх үйлчилгээний зорилго:
   - Авто зам, замын байгууламжийн магадлашгүй ажлын зардлыг тооцох аргачлал гарснаар төслийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулж, нөөцийг зөв хуваарилах.
   - Батлагдсан журам, маягт байхгүйгээс зарим Захиалагч байгууллага магадлашгүй ажлын нөөц хөрөнгийг янз бүрээр тооцож гүйцэтгэгчийг хохироох асуудал гарч байгааг журам гаргаснаар шийдвэрлэнэ.
3. Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ:
   - Авто зам, замын байгууламжийн магадлашгүй ажлын зардлыг тооцох аргачлалын төслийг цаашид ашиглах эрх зүйн үндэслэл, бусад хууль, дүрэм, журмын

	уялдаа холбоог сайтар судлан дүрмийн төслийг боловсруулах.
	• Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын явцад зайлшгүй хийх нэмэлт ажлыг магадлашгүй ажлын зардлын тооцоонд тооцож оруулахдаа уг ажлын тусгах үндэслэл, тооцох журмын заалтын нэр төрөл тус бүрийг нарийвчилсан судалгааны үндэслэлтэй гаргана.
4. Зөвлөх үйлчилгээний хүрээнд гүйцэтгэх ажил, үүрэг:	• Авто зам, замын байгууламжийн магадлашгүй ажлын зардлыг хэрхэн тооцох талаар суурь судалгааг хийж гүйцэтгэх.
	• Суурь судалгаан дээр үндэслэсэн гадаад болон дотоод SWOT шинжилгээ, болон үнэлгээний арга аргачлалын тусламжтайгаар журмын төслийг боловсруулсан байна.
	• Авто зам, замын байгууламжийн магадлашгүй ажлын зардлыг тооцох аргачлалын төслийг бусад хуультай уялдуулах, нөлөөллийн шинжилгээг хийж гүйцэтгэх.
	• Холбогдох байгууллагуудаас санал зөвлөмжийг авч журмын төсөлд тусгах.
5. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд ашиглах, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд	• Монгол Улсын Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.6 дүгээр заалт
6. Зөвлөх үйлчилгээний баримт бичгийн бүрдэл:	• “Авто зам, замын байгууламжийн магадлашгүй ажлын зардлыг тооцох аргачлал”-ын төслийн эхний болон эцсийн шатны тайлан, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж
7. Зөвлөх үйлчилгээний үр дүн:	• “Авто зам, замын байгууламжийн магадлашгүй ажлын зардлыг тооцох аргачлал” батлагдсан байна.
8. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх байгууллага:	• Тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлага бүхий Зөвлөх баг болон хуулийн этгээд (Сонгон шалгаруулалтаар) байна.
9. Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа:	• 10 сар (Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш)
10. Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр:	• 50.0 төгрөг.
	• “Авто замын норм нормативын сан”.
11. Онцгой нөхцөл	• Авто замын тухай хууль, бусад хууль, дүрэм журам, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй мөн шинээр болон шинэчлэн батлагдсан стандарт норм норматив, техникийн баримт бичгүүдтэй уялдуулах, нийцүүлэх.

- Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг MNS 2492:2004 “Эрдэм шинжилгээний ажлын тайлан. Бүтэц шаардлага” стандартын дагуу боловсруулах.
- Салбарын мэргэжлийн холбоод, төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ сургалт судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, зөвлөх инженерүүдээс албан бичгээр санал авах, саналыг аргачлалын төсөлд хэрхэн тусгасан талаар саналын товчоо, тайлбар танилцуулга гаргах.
- Төслийг боловсруулах явцад салбарын байгууллага, ИТА-уудыг хамруулсан уулзалт ярилцлагыг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, төсөлд санал зөвлөмж авч тусгасан байх.
- Аргачлалын эцсийн төсөл (Редакц, шүүмжийн ажлын хэсгийн төслийн эцсийн тайланг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар эцсийн дүгнэлт гарсан байх)-ийг Зам, тээврийн яамны Авто замын салбарын Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж зөвлөмжийн дагуу боловсруулалтыг хийж, танилцуулгын хамт Захиалагчид хүргүүлэх.

  Захиргааны ерөнхий хуулийн 61-р зүйлийн 61.4 дэх хэсэгт заасны дагуу батлагдсан аргачлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, бүртгүүлэхэд Захиалагчтай хамтран ажиллах.
- Зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, тайлан, боловсруулагдсан аливаа программ хангамж, түүний эх код нь “Зохиогчийн эрхийн тухай” хуулийн 19.1, 19.2, 19.5 дугаар зүйл, Оюуны өмчийн тухай хуулийн 7.2, 7.3 дахь зүйлийн дагуу Зам, тээврийн хөгжлийн төвийн өмч болно.

ХЯНАСАН:
Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга — Э.БАЛТ

БОЛОВСРУУЛСАН:
Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн мэргэжилтэн — О.ДОЛГИОН